



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 8/352

Улаанбаатар хот


Г Журам батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,  
Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн  
ТУШААХ нь:

1. "Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т даалгасугай.

САЙД

С.ЭНХБОЛД



Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
07 сарын 04 өдрийн дугаар  
тушаалын хавсралт

## ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтыг хангах үүднээс эрүүл мэндийн байгууллага бүр үйлчлүүлэгчийг “ЗӨВ” танин тодруулгыг хийж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг эрүүл мэндийн байгууллагууд мөрдөж, тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж үйлчлүүлэгчийг буруу танин тодруулснаас үүсэх тохиолдлоос сэргийлж ажиллах.

1.3. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн эрхлэгч, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба /баг/ хяналт тавьж ажиллана.

1.4. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулаагүйгээс үүссэн тохиолдлыг тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба /баг/ нь Эрүүл мэндийн сайдын холбогдох журмын дагуу бүртгэн, хариу арга хэмжээ авч ажиллана.

### Хоёр. Нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах гэж тусlamж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор тухайн үйлчлүүлэгчийн хувь хүний өвөрмөц мэдээллийг ашиглан зөв дахин магадлах үйл явцыг хэлнэ.

2.2. Бугуйн зүүлт гэж үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгад ашиглах хувь хүний өвөрмөц мэдээлэл бүхий өнгөөр ялгасан нэг удаагийн хэрэглээний зориулалтын тузан бугуйвчийг хэлнэ.

2.3. Хувь хүний өвөрмөц мэдээлэл гэж үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгад ашиглах тухайн үйлчлүүлэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он сар болон бусад мэдээллийг хэлнэ.

### Гурав. Танин тодруулах ерөнхий зарчим

3.1. Үйлчлүүлэгчийн хувь хүний өвөрмөц мэдээллийг ашиглана.

3.2. Үйлчлүүлэгчийн хэвтэн эмчлүүлж буй өрөөний болон давхрын дугаар, орны байрлал, хувцаслалтыг танин тодруулгад ашиглахгүй.

3.3. Бугуйн зүүлтний өнгийг энэхүү журмын 4.11-д заасны дагуу хэрэглэнэ.

3.4. Үйлчлүүлэгчийг мөн эсэхийг тодруулахдаа асуухаас илүүтэйгээр өөрөөр нь хэлүүлэхийг чухалчилна.

### Дөрөв. Үйлчлүүлэгчийг танин тодруулах үйл ажиллагаа

4.1. Дараах тохиолдлуудад үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгыг заавал хийнэ.

Үүнд:

- 4.1.1. Эмч үзлэг хийхийн өмнө
  - 4.1.2. Шинжилгээнд сорьц авахын өмнө
  - 4.1.3. Эмийн эмчилгээний өмнө
  - 4.1.4. Дурс оношилгоо, багажийн шинжилгээ хийхийн өмнө болон хариу хүргэх үед
  - 4.1.5. Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө
  - 4.1.6. Эмчилгээ, оношилгоо, ажилбарын өмнө
  - 4.1.7. Мэс засал, мэс ажилбарын өмнө
  - 4.1.8. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэхийн өмнө
  - 4.1.9. Хоол сойх, эмчилгээний хоол түгээхийн өмнө
  - 4.1.10. Үйлчлүүлэгч нас барах тохиолдолд
- 4.2. Дээрх үйлдэл бүрийн өмнө үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахдаа овог нэрийг чанга тод дуугаар дуудаж, үйлчлүүлэгчтэй хамт дахин овог, нэр, төрсөн он сар, өдрийг баталгаажуулна.
  - 4.3. Үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг хэрэгжүүлэхдээ тухайн тусламж үйлчилгээ бүрийн өмнө дараах аргуудаас хамгийн зохистой гэж үзсэн хоёроос доошгүй аргыг хэрэглэнэ. Үүнд:
    - 4.3.1. Овог нэрийг бүтнээр
    - 4.3.2. Нас хүйсийг асуух
    - 4.3.3. Төрсөн огноог асуух
    - 4.3.4. Гэрийн хаягийг хэлүүлэх
    - 4.3.5. Бугуйн зүүлтэн дээрх мэдээлэлтэй тулгах
    - 4.3.6. Бичиг баримт болон цахим санд бүртгэгдсэн зурагтай тулгах
    - 4.3.7. Хэвтэн эмчлүүлж буй тасгийг асуух
  - 4.4. Эрүүл мэндийн байгуулага нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахын тулд үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг хэрэглэнэ.
  - 4.5. Эмнэлгийн цахим системд үйлчлүүлэгчийн бүртгэх үед шаардлагатай мэдээллийг эрүүл мэндийн ажилтан лавлан бугуйн зүүлтийг зүүнэ.
  - 4.6. 0-18 насны хүүхэд бол эрүүл мэндийн ажилтан өөрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас үйлчлүүлэгчийн мэдээллийг асууж эмнэлгийн мэдээллийн системд бүртгэнэ.
  - 4.7. Бугуйн зүүлтийг дараах үйлчлүүлэгчид хэрэглэнэ.
    - 4.7.1. Амбулатори, яаралтай тусламж, үйлчилгээг 4 цагаас дээш хугацаагаар авах үйлчлүүлэгчид
    - 4.7.2. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авах үйлчлүүлэгчид
    - 4.7.3. Өдрийн эмчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгчид
  - 4.8. Бугуйн зүүлтэнд үйлчлүүлэгчийн дараах мэдээлэл бичигдэнэ. Үүнд:
    - 4.8.1. Үйлчлүүлэгчийн эцэг /эх/-ийн нэр
    - 4.8.2. Төрсөн он, сар, өдөр
    - 4.8.3. Нас, хүйс
    - 4.8.4. Цахим бүртгэлийн дугаар
    - 4.8.5. Тухайн эрүүл мэндийн байгууллага шаардлагатай мэдээллийг нэмж болно.
  - 4.9. Бугуйн зүүлтэнд дараах мэдээллийг оруулахыг хориглоно. Үүнд:
    - 4.9.1. Товчилсон үг ашиглах

- 4.9.2. Үйлчлүүлэгчийн хоч болон дуудах нэр ашиглах
- 4.10. Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ авах тасаг нэгжид хүлээн авсан эмнэлгийн ажилтан шаардлагатай мэдээлэл, эрүүл мэндийн байдал, эмнэлзүйн онцлог, хэрэглэгдэх эм, тариа, тухайн тасаг, нэгжид ижил нэртэй үйлчлүүлэгч байгаа эсэхийг тодруулан бугуйн зүүлтний өнгийг өөрчлөх эсвэл нэмж зүүлт хэрэглэнэ.
- 4.11. Бугуйн зүүлтний өнгө нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:
- 4.11.1. “Ягаан өнгө” эрчимт эмчилгээний үйлчлүүлэгчид
  - 4.11.2. “Шар өнгө” бугуйн зүүлтийг унах эрсдэлтэй үйлчлүүлэгчид
  - 4.11.3. “Улаан өнгө” бугуйн зүүлтийг харшилтай (Эм тариа, хоол хүнс гм)
  - 4.11.4. “Цагаан өнгө” бугуйн зүүлтийг эрсдэлгүй үйлчлүүлэгчдэд хэрэглэнэ.
- 4.12. Үйлчлүүлэгчийн хувь хүний онцлог, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан харгалзах өнгө тус бүрээс бугуйн зүүлтийг хэрэглэж болно.
- 4.13. Бугуйн зүүлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 4.13.1. Үйлчлүүлэгчийн бугуйн зүүлт үйлчлүүлэгч бүрт тохиорх хэмжээтэй байх
  - 4.13.2. Бат бөх, зөөлөн, уян хатан, усны хамгаалалттай
  - 4.13.3. Харшил төрүүлэхгүй материалтай
  - 4.13.4. Гар угаалга болон ариутгалын бодист тэсвэртэй
  - 4.13.5. Нэг удаагийн хэрэглээний байх
- 4.14. “Бугуйн зүүлт”-ийг зүүх, буцаан авах
- 4.14.1. Бугуйн зүүлтийг насанд хүрэгчдийн зүүн гарын бугуйн хэсэгт, хүүхдийн зүүн хөлийн шилбэнд зүүнэ.
  - 4.14.2. Хэрэв зүүн гар тайрагдсан эсвэл зүүн гартаа гурсын тоног төхөөрөмж холбогдсон бол баруун гарын бугуйнд зүүнэ. Хоёр гаргүй тохиолдолд хөлийн шилбэнд байрлуулна.
  - 4.14.3. Хэрэв үйлчлүүлэгч бугуйн зүүлт зүүхээс татгалзах, бугуйн зүүлтээс харшилсан тохиолдолд тэмдэглэл үйлдэнэ, бугуйн зүүлтийг зүүлгэхгүй.
  - 4.14.4. Ухаангүй болон дагалдан ирсэн хүнгүй таних боломжгүй тохиолдолд өвчний түүхийн дугаар (яаралтай тусламжийн хуудасны дугаар) бүхий бугуйн зүүлтийг зүүлгэнэ. Энэхүү зүүлтийг үйлчлүүлэгчийг зөв таних хүртэл зүүлгэнэ.
  - 4.14.5. Бугуйн зүүлтийг эмнэлгээс гарах хүртэл зүүлгэх ба үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарах, эмнэлэг хооронд шилжүүлэх үед үйлчлүүлэгчээс бугуйн зүүлтийг авна.
- 4.15. Бугуйн зүүлт дээрх мэдээлэл буруу, арилсан, гээгдсэн бол зөв мэдээлэлтэй бугуйн зүүлтээр нэн даруй сольж үйлчлүүлэгчийн мэдээллийг дахин тулгана.
- 4.16. Үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд бугуйн зүүлт дээрх мэдээллийг нягтлан, бугуйн зүүлтийг тайлалгүй шарил хадгалах өрөө рүү зөөврөлнө.
- 4.17. Бугуйн зүүлтээр үйлчлүүлэгчийг танин тодруулах үед гарч болох алдаанаас сэргийлэх. Үүнд:
- 4.17.1 Бугуйн зүүлт солигдсон байх
  - 4.17.2 Нэгээс олон бугуйн зүүлттэй байхад зүүлт дээрх мэдээллийд зөрүүтэй байх
  - 4.17.3 Бугуйн зүүлт дээрх мэдээлэл дутуу байх
  - 4.17.4 Бугуйн зүүлт дээрх мэдээлэл буруу байх

- 4.17.5 Бугуйн зүүлт дээрх мэдээлэл гаргацгүй байх
- 4.17.6 Бугуйн зүүлт дээрх мэдээлэл арилсан байх
- 4.17.7 Эцэг/эх/-ийн нэр болон өөрийн нэр ижил байх
- 4.17.8 Төрсөн он, сар, өдөр ижил үйлчлүүлэгч

**Тав. Харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй үйлчлүүлэгчийг танин тодруулах**

5.1. Дараах тохиолдолд харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй үйлчлүүлэгчид хамааруулна. Үүнд:

- 5.1.1. Түр зуурын харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгч (Ухаангүй, ихээр эм хэрэглэсэн, амьсгалын аппараттай байгаа, эрчимт эмчилгээний тасагт байгаа, сэрээх өрөөнд байгаа үйлчлүүлэгч)
- 5.1.2. Хэл нэвтрэлцэхгүй, орчуулагч байхгүй үйлчлүүлэгч
- 5.1.3. Нярай хүүхэд
- 5.1.4. Танин мэдэхүйн алдагдалтай (тэнэгрэл, зан төрхийн өөрчлөлтийн эмгэгүүд)
- 5.1.5. Хэлгүй, дүлий үйлчлүүлэгчийг харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид хамруулна.

5.2. Энэхүү журмын 5.1-д хамаарах үйлчлүүлэгчдэд дараах аргаар танин тодруулга хийнэ.

- 5.2.1. Үйлчлүүлэгчийн ар гэрийн гишүүд, асран хамгаалагчаас шаардлагатай мэдээллийг авч баталгаажуулна.
- 5.2.2. Хэрэв хувь хүний мэдээллийг тодруулах боломжгүй бол “Овоггүй, Нэргүй” гэж нэрлэн цахим сүлжээнд бүртгэнэ.
- 5.2.3. Үйлчлүүлэгчийн мэдээлэл тодорхой болсон даруйд мэдээллийг засаж бүртгэн бугуйн зүүлтийг хэрэглэнэ.
- 5.2.4. Шаардлагатай тохиолдолд дохионы хэлний орчуулагчаар дамжуулан танин тодруулга хийнэ.

### **Зургаа . Мэс заслын үед танин тодруулах**

- 6.1. Бугуйн зүүлтийг үйлчлүүлэгчийн биеийн мэс засал хийгдэхгүй талд зүүнэ.
- 6.2. Мэс засал хийхэд үйлчлүүлэгчид мэдээ алдуулалт болон унтуулга хийхээс өмнө буюу мэс заслын өрөөнд орохоос өмнө дараах танин тодруулгыг хийнэ.
  - 6.2.1. Үйлчлүүлэгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр
  - 6.2.2. Регистрийн дугаар
  - 6.2.3. Төрсөн он, сар, өдөр
- 6.3. Мэс засал буюу мэс ажилбарын өмнө “Time-out” буюу “Завсарлага” хийнэ. Үүнд:
  - 6.3.1. Хагалгааг гардан хийх оператор эмч мэс заслын бүхий л явцыг удирдах ба “Завсарлага –ийг эхлүүлж, мэс заслын бүрэлдэхүүнд томилогдсон эмч, сувилагч нар нэг бүрчлэн өөрсдийгөө танилцуулах.
  - 6.3.2. Оператор эмч үйлчлүүлэгчээс овог нэр, нас, ямар хагалгаанд орохоор төлөвлөснийг дахин асууж, өвчний түүхтэй тулгах
  - 6.3.3. Хагалгааны талбайд тэмдэглэл хийсэн эсэхийг шалгана.
- 6.4. Мэс заслын талбайн тэмдэглэгээг эмчлэгч эмч хийнэ. Талбайн тэмдэглэгээг хийхдээ дараах байдлаар магадлана. Үүнд:

- 6.4.1. Аман хэлбэрээр тодруулга хийх
  - 6.4.2. Мэс заслын хуваарътай тулган үзэх
  - 6.4.3. Мэс заслын зөвшөөрлийн хуудас, өвчний түүхийг шалгах
- 6.5. Мэс заслын талбайд тэмдэглэл хийх:
- 6.5.1. Үйлчлүүлэгчийн ухаан санааны байдал хэвийн байхад буюу унтуулга, мэдээ алдуулалт хийхээс өмнө хийнэ.
  - 6.5.2. Хос эрхтэн, олон мөчид ба нуруу нугалмын мэс заслын үед заавал хийнэ.
  - 6.5.3. Мэс засал хийх эмч арьсны маркер ашиглан тэмдэглэгээг хийнэ.
  - 6.5.4. Мэс засал хийх талбайд тухайн мэс заслын онцлогоос хамааран тохирох тэмдэглэгээг хийнэ.
  - 6.5.5. Талбайн тэмдэглэгээг хийхдээ "Х" тэмдэг тавихыг хориглоно.
  - 6.5.6. Мэс заслын талбайн тэмдэглэгээ нь талбайг ариутгаж, тусгаарласны дараа /тусгаарлах даавуу тавьсны дараа/ харагдахуйц байна.

#### **Долоо. Хяналт, үнэлгээ**

- 7.1. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан үйлчлүүлэгчийг танин тодруулах журмыг баримтлаагүй тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу мэдээлэх хуудас бөглөж, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба болон багт мэдээлнэ.
- 7.2. Энэхүү журмын дагуу эрүүл мэндийн байгууллага бүр дотоод хяналт, үнэлгээг хийнэ.